



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 сарын 11 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1-д заасан мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийн “, шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 24.7-д заасан мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргах” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР